

## ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙ

2018 оны эцсийн байдлаар 1899 аж ахуй нэгж, өрхөд 75.2 мянган сүүний үхэр, 330 аж ахуйн нэгж, өрхөд 23.8 мянган махны үхэр, 87 аж ахуйн нэгжид 32.0 мянган мах, ноосны нарийн, нарийвтар ноост хонь, 845 өрх, аж ахуйн нэгжид 29.4 мянган гахай, 1176 өрх, аж ахуйн нэгжид 1.2 сая өндөглөгч тахиа, 388 өрх, аж ахуйн нэгжид 7562 бүл зөгий, мөн түүнчлэн зарим иргэд цаа буга, илжиг, загас, цөөн тооны цацагт хяруул, галуу, нугас, туулай зэргийг үржүүлж байна. Гахайн аж ахуйд хүндрэлтэй байдал үүсээд байна. Энэ төрлийн үржлийн аж ахуй байхгүйгээс сүрэг сэлбэх боломжгүй, янз бүрийн өвчин эмгэгт өртөх зэрэг шалтганаар 2019 оны эхэнд 3000 гаруй гахайг зориудын устгалд оруулсан. Мөн гахай үржүүлэгчид гахайн аж ахуйн үржлийн ажлыг сайжруулах санаачлага гаргах боловч хөрөнгө, зээлийн дутагдалтай байдлаас шалтгаалан тэдний асуудал шийдэгдэж чадахгүй байна.

Монгол орны цаг агаарын өөрчлөлт, ган зудын давтамж, газрын доройтол, бэлчээрийн хомсдол, даацын хэтрэлт, малын тооны хэт өсөлт, тэжээлийн хангамж хүрэлцээгүй зэрэг нь нөөцийн хязгаарлагдмал байдлыг үүсгэж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, малчдын эрэлт хэрэгцээнд тулгуурласан бодлого, төлөвлөлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болоод байна.

### 2018 онд хийсэн ажлуудаас товч:

1. Малын удмын сангийн төвийн үйл ажиллагааг нь өргөжүүлэн, малын үржүүлэг, биотехнологийн ажил, үйлчилгээг дэлхийн жишигт нийцсэн технологиор өргөн цар хүрээтэйгээр явуулах үндэсний чадавхийг бий болгох зорилгоор “Монгол мал” үндэсний хөтөлбөрт тусгагдсан томоохон зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт 22,3 га газрыг авч, инженер-геологийн судалгаа болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийсний үндсэн дээр цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, иж бүрэн зураг төслийг гүйцэтгэн 2013-2017 онд бүтээн байгуулалтын ажлыг хийж, 2017 оны 11 сард эхний ээлжийн гүйцэтгэлээр баригдсан 18 барилга, инженерийн иж бүрэн шугам сүлжээний ажлыг улсын комисст хүлээн авснаар 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдөр нээлтээ хийн, үйл ажиллагаагаа эхлээд байна.



Малын нөхөн үржихүйн биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэн Бүрэн хүчин чадалтай лабораторийг тохижуулан, малын генийн санг баяжуулж дотоодод үйлдвэрлэх гойд ашигт шимт малын гүн хөлдөөсөн үрийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор тохижуулав.

УСҮТ-д нөөцөнд байгаа гүн хөлдөсөн дараах үрүүд байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн генийн санд хадгалагдаж буй гүн хөлдөөсөн үрийн тоо			
№	Нэр	Тоо ширхэг	Генийн санд хадгалагдах байдал
1	Алатау бух	1874	Монгол малын чанарыг сайжруулах болон эрчимжсэн аж ахуйн бүс нутгийн хүрээнд богино хугацаанд ашиглагдах гүн хөлдөөсөн үр
2	Ангус бух	1502	
3	Герефорд бух	383	
4	Лимүзин бух	2863	
5	Сименталь бух	10114	
6	Хар тарлан бух	11187	
7	Дорсет /хуц/	415	
8	Альпин ухна	467	
9	Заанен ухна	118	
10	Авсралийн мернус	206	
11	Каракуль хуц	10	
	Суффолк гадаад	169	
	<b>Дүн</b>	<b>29308</b>	
1	Сэлэнгэ бух	175	Монгол малын генетик нөөцийг хамгаалах зорилгоор урт хугацаанд хадгалагдах гүн хөлдөөсөн үр
2	Сарлагийн үр	215	
3	Дотоод үр /бух/	2082	
4	Өнжүүл ухна	190	
5	Альпин ухна	10	
6	Буурал ухна	130	
7	Барга хуц	1070	
8	Ерөө хуц	1982	
9	Жаргалант хуц	364	
10	Орхон хуц	2870	
11	Сартуул хуц	1800	
12	Сүмбэр саарал	1299	
13	Тал нутгийн цагаан хуц	2749	
14	Үзэмчин хуц	4514	
15	Халх хуц	420	
16	Хангай хуц	3188	
17	Эдельбайев хуц	1315	
	<b>Дүн</b>	<b>24373</b>	
	<b>Нийт дүн</b>	<b>53681</b>	
№	Төрөл	Үүлдэр	Тоо ширхэг
1	Ямаа	4	915
2	Хонь	14	22371
3	Үхэр	8	30395
			53681

Иргэд. аж ахуйн нэгжүүд УСҮТ-тэй холбоо тогтоож захиалгаар үйлчлүүлж байна.

2. ХХААХҮСайдын 2017 оны 12-дугаар сарын 22-ны өдрийн А-179 дүгээр тушаалыг хэрэгжүүлж Улсын төсвийн санхүүжилтээр 2018 онд сүүний үхрийн удам гарваль, ашиг шимийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга хэмжээг гүйцэтгэхээр захиалагч Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, гүйцэтгэгч Малын удмын сангийн үндэсний төв хооронд байгуулсан 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Сүүний үхрийн удам гарваль, ашиг шимийн бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх тухай” гэрээний дагуу зохион байгуулсан. 2018 онд “Сүүний үхрийн гарваль, ашиг ашиг шимийн бүртгэл мэдээллийн сан”-д эрчимжсэн мал аж ахуй

эрхлэх бүс нутгийн 9 ферм, 293 тугал, 10321 сүүний гарц, сүүний бүрэлдэхүүний гурван үндсэн үзүүлэлт, 1331 үхрийн амьдын жингийн бүртгэл, мэдээллийг нэмсэн буюу 2018 онд мэдээллийн санг нийт дүнгээр 10321 /арван мянга гурван зуун хорин нэг/ тоон мэдээллээр баяжуулав.

3. Тоо толгой нь цөөрч, удмын сан нь алдагдах хэмжээнд хүрсэн малын шилмэл хээлтүүлэгчээс үр, хөврөл нөөцлөх, удмын санг хамгаалах ажлыг холбогдох газар хүргүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлыг зохион байгуулахад тухайн үүлдэр, үржлийн хэсгийн малыг гаргаж авахад оролцсон малын хээлтэгч, хээлтүүлэгчийг импортлон зохиомол хээлтүүлэг хийх, энэхүү арга нь биотехнологийн шинжлэх ухааны хамгийн хялбар, оновчтой, хямд арга бөгөөд мал амьтны удам зүйг сайжруулах тоо толгойг богино хугацаанд өсгөхөд түгээмэл хэрэглэж байна.

4. 2018 онд сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж байгаа нийслэлийн ойролцоох аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг хэлэлцэн Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд зарлан, нийт 39 төсөл ирүүлснийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн малын чанарыг сайжруулах, фермийн байр засах, тэжээлийн нөөц бүрдүүлэх болон тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд нь зориулж сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 27 аж ахуйн нэгжид нийт 509 сая төгрөгийн зээлийг 5-н жилийн хугацаатай жилийн 3,6 хувийн хүүтэй олгохоор ХХААХҮС-ын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-163 дугаар тушаал гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулав.

5. Эрчимжсэн аж ахуйн тэжээлийн үйлдэрлэл нэмэгдүүлэх зорилгоор "Уурагт таримал тэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх" төсөл зарлан 17 аж ахуйн нэгжийг сонгон 1.0 тэрбум төгрөгийн зээл олгосноор энэ онд тэжээлийн ургамал тариалалт 1000 га-гаар нэмэгдэв. Мөн энэ онд ЖДҮХС-аас төслийн шаардлага хангасан мах, сүүний үхрийн фермерийн 30 аж ахуйн нэгжид 14.1 тэрбум төгрөгийн зээлийн

6. Сүүний боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр тогтвортой хангах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжих зорилгоор "Сүүний хөргөлтийн танк, цахилгаан хөдөлгөөнт саалтуур" нийлүүлэх тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан. Гэрээний дагуу нийлүүлсэн тоног төхөөрөмжийг 2017 оны 11-р сарын 23-нд хүлээн авч Мал хамгаалах санд шилжүүлсэн. Уг тоног төхөөрөмжийг хувиарлах ажлыг МХС-тай хамтран зохион байгуулж байна. Энэ арга хэмжээний дүнд сүүний хөргөлтийн танк 10 ширхэг, цахилгаан хөдөлгөөнт 144 ширхэг байгааг сүүний чиглэлийн эрчимжсэн үхрийн аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр МХС-аар дамжуулан олгоод байна..

7. "Зөгийн аж ахуй эрхлэж буй аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх" төсөл сонгон шалгаруулалтыг зарлан 7 аж ахуйн нэгжид нийт 35 сая төгрөгний зээлийг жилийн 3,6 хувийн хүүтэй 5-н жилийн хугацаатай олгохоор ХХААХҮС-ын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А-114 дүгээр тушаал гарган хэрэгжүүлэв.

8. Зөгийн аж ахуйг дэмжих зорилгоор 34.1 сая төгрөгний үнэ бүхий 231 ширхэг башкер үүлдрийн эх зөгийг иргэн, аж ахуйн нэгжид зээл хэлбэрээр олгох ажлыг Мал хамгаалах сан, Монголын зөгийчдийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулав. 2018 онд энэ ажлын үр дүнд зөгийн бүлийн тоо 250-аар нэмэгдсэн.

9. Сэлэнгэ аймгийн Шаамар сум "Дулаанхаан тосгонд зөгийн зорь барих" ажлыг гүйцэтгэхээр захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд СЭСБ-88/2018 дугаартай гэрээ байгуулан 39,530,019 /Гучин есөн сая таван зуун гучин мянга арван есөн/ төгрөгт багтаан гүйцэтгэв.

10. "Шинэ хөдөө төсөл, жимс жимсгэнэ, малын үржил /Булган/" нийлүүлэгчийг сонгох" тендрийг цахим хэлбэрээр зарлаж, "Цэвэр үүлдрийн өндөр ашиг шимт бух, хуц, ухна, гүн хөлдөөсөн үр, зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх" нэгдүгээр багцад "Герифорд" үүлдрийн үржлийн өсвөр бух 25 толгой, Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух 100 толгой, Баяд үүлдрийн үржлийн өсвөр хуц 160 толгой, Дархад үүлдрийн үржлийн өсвөр хуц 200 толгой, Эрчимийн хар омгийн үржлийн өсвөр ухна 180 толгой, Герифорд үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үр 6000 ширхэг, зохиомол хээлтүүлгийн 4 иж бүрдэл тоног төхөөрөмжийг "Си Эйч Си И Кей" шалгарч гэрээ байгуулан гэрээний үүргээ тус тус 100 хувь биелүүлсэн.

11. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутагт ажиллаж байгаа болон ажиллахгүй байгаа малын тэжээлийн үйлдвэр, цехүүдийн судалгааг авч нэгтгэв. Улсын хэмжээнд 166 тэжээлийн үйлдвэр, цех байгаагаас 68 нь байнгын болон түр ажиллагаатай, 49 нь огт ажиллагаагүй байна. Судалгаан дээр тулгуурлан тэжээлийн үйлдвэрүүдийн байршлыг бүсчлэн гаргав.

Манай улсад нутагшсан бургалтай сортын царгасны үр үржүүлдэг “Хүүлэй хааны хишиг” ХХК-тай хамтран байгалийн эрсдэлд өртөмтгий аймгуудад уурагт таримал тэжээл тариалах ажлыг эхлүүлж Булган, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 100 га-д царгас тариалах, үр үржүүлэх ажилд дэмжлэг үзүүлж тэжээл үйлдвэрлэлийг 2018 онд 1200 тн ногоон тэжээлээр нэмэгдүүлсэн ба 1000 га-д царгас тариалах ажлыг зохион байгуулсан. Мөн царгасны үр үржүүлэх 720 га талбай, хөх тарианы үр үржүүлэх 200 га талбайг нэмэгдүүлж малын тэжээл тариалалалтыг 0,05 хувиар өсгөсөн байна..

### **2018 онд Улсын аварга фермерээр шалгарсан иргэд, аж ахуйн нэгж**

1. Архангай аймгийн Чулуут сумын зуун мод багийн сарлагийн үнээний фермер Лундаагийн Мясардорж,
2. Увс аймгийн Улаангом сумын 8- р багийн фермер Төлхийн Алтангэрэл,
3. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 13 –р хорооны шувууны фермер “Угтуул-Алтай” ХХК тус тус шалгарсан.

### **2019 оны эхний улиралд**

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг танилцуулах, хөтөлбөрийн төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэх зөвлөлдөх уулзалт

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг танилцуулах, хөтөлбөрийн төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэх зөвлөлдөх уулзалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас холбогдох төрийн байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодыг оролцуулан өнөөдөр (2019.02.27) зохион байгууллаа. Оролцогчид дээр дурдсан хөтөлбөр, энэ онд мал аж ахуйн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлууд, тариалангийн бүс нутгийн тухай, эрчимжсэн мал аж ахуйн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх шаардлага, боломжийн талаар танилцуулж, төгсгөлд нь хэлэлцүүлэг өрнүүлсэн.



Малчдын эрэлт хэрэгцээнд үндэслэн боловсруулсан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 400 дугаар тогтоолоор батлагдсан. Хөтөлбөрт Мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн төрөлжүүлж хөгжүүлэх, импортыг бууруулж, экспортыг дэмжих, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилго бүхий 7 үндсэн зорилтын хүрээнд 54 зорилтот үйл ажиллагааг 2 үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх 158 арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан төр, төрийн бус, эрдэмтэн, судлаач, иргэн, мал аж ахуйн нэгж холбогдох байгууллагуудын дунд 4-н удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулан гаргасан саналыг тусгаад байгаа юм.

Төлөвлөгөөний төслийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж Сайдын 2019 оны 120 дугаар тушаалаар тушаалаар батлуулсан. ЭМААХДҮХ-ийн/2019-2023 он/ төлөвлөгөөг та бүхэнд танилцуулж байна.

Эрчимжсэн мал аж ахуйн төвийн бүсийн зөвлөгөөн дархан хотод зохион байгуулав.

Дархан-Уул аймагт /2019.04.12/ Эрчимжсэн мал аж ахуйн төвийн бүсийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулллаа. Төвийн бүсийн гэгддэг Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Төв аймгийн мал аж ахуйн салбарын болоод холбогдох яамны төлөөлөгчид, эрдэмтэн, багш, судлаачид чуулсан юм. Энэ зөвлөгөөнөөр “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн

танилцуулга, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцсэн. Сүүлийн жилүүдэд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тодорхой түвшинд эрчимжүүлж, улмаар хот, суурин газрын төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортыг үе шаттай бууруулах шаардлага Монгол улсад тулгараад байна.



"Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийг баталсан. 2019-2023 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжих хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг бүсчлэн төрөлжүүлэх бодлогыг баримталж байгаа юм. Энэ ч үүднээсээ Монгол улсын бүс тус бүрт уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж эрчимжсэн МАА-г хэрхэн хөгжүүлэх, юун дээр анхаарах талаар хэлэлцэж байна. Энэ үеэр эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих, уг салбарт техник технологийн дэвшлийг нутагшуулах зэрэг олон чухал зорилтыг өмнөө тавьсан

Энэ зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж буй Монгол улсад Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх /SECiM/ төсөл Дархан-Уул аймагт амжилттай хэрэгжиж байна. Тус төслөөс эрчимжсэн мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх хүрээнд олон ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлж байгаа олон жишээг энэ зөвлөгөөний үеэр танилцууллаа. Эдгээрээс онцлоход энэ оны ирэх 6 дугаар сараас эхлэн Хонгор суманд сүүний хөргөлтийн төвийг байгуулахаар ажиллаж байгааг дурдлаа.

Төвийн бүсийн энэхүү зөвлөгөөний үеэр эрчимжсэн МАА-г хөгжүүлэхийн тулд жижиг, дунд, том фермер, аж ахуйн нэгжийг оновчтой тодорхойлох, үүний дагуу стандарт тогтоох, гадаадаас өндөр ашиг шимт мал оруулж ирэх асуудалд уян хатан хандах, малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулах зориулалт бүхий үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих улмаар өвс, тэжээлийн газар, талбайг шийдэж өгөх, жижиг оврын тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх зэрэг саналуудыг зөвлөгөөнд оролцогчид гаргасан юм.

2019 оны 1 дүгээр улиралд Азийн Хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хөрөнгөөр Швацарь улсаас оруулж ирсэн сүүний чиглэлийн “Голштейн” (Хар тарлан), “Симменталь”, мах-сүүний чиглэлийн “Brown Swiss”, “Original Brounvieh”, “Ангус” \Улаан\, махны чиглэлийн “Лиммузин” үүлдрийн өндөр ашиг шимт хүйс жолоодсон 1200 тун охин үр, 12800 тун гүн хөлдөөсөн үр, нийт 14000 тун үрийг,

Төрлөөр нь авч үзвэл - Өндөр ашиг шимт хүйс жолоодсон сүүний чиглэлийн Хар тарлан “Голштейн” 100, хар тарлан 100, “Симменталь” 200, мах-сүүний чиглэлийн “Алатау” үүлдэр “Brown Swiss” 100, “Original Brounvieh” 200, “Х-Benissimo” 100, “Ангус” \Улаан\ 200, махны чиглэлийн “Лиммузин” үүлдрийн 200, нийт 1200 тун үр нь:

Гүн хөлдөөсөн сүүний чиглэлийн “Хар тарлан” 2600, Симменталь 2600, мах-сүүний чиглэлийн “Ангус” 1500, “Алатау” 4600, махны чиглэлийн “Лимузин” 1500, нийт 12800 тун үрийг 4-р сарын 29-нд МУСҮТ-д хүлээлгэж өгсөн

2019 оны 05-р сарын 24-нд Дорнод аймагт Эрчимжсэн мал аж ахуйн Зүүн бүсийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.